Атопийн дерматитын эмнэлзүйн шинжүүд болон амьдралын чанарт зүү эмчилгээний үзүүлэх нөлөө

Т.Лхамжав[1], Б.Хулан[1], Г.Намгар[1], Я.Энхтөр [2], Б.Лагшмаа[1]
[1]АШУҮИС-ийн Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль
[2]АШУҮИС-ийн Анагаах Ухааны сургууль
lkhamjav@mnums.edu.mn

Түлхүүр үг
Атопийн дерматит, зүү эмчилгээ, загатнаа, амьдралын чанар

Товч утга
Монгол улсад 2012 оноос хойш атопийн дерматитын (АД) тархалт тасралтгүй өсөх хандлага ажиглагдаж байгаа бөгөөд АӨСҮТөвийн амбулаторийн тэргүүлэх таван өвчлөлд багтаж байна. Бид энэхүү судалгааг санамсаргүй хяналтат эмнэлзүйн туршилт судалгааны загвараар хийж гүйцэтгэлээ. Судалгаанд хамрагдагсдыг санамсаргүй түүврийн аргаар зүү эмчилгээний (n=30) болон хяналтын (n=30) бүлэгт хуваажнийт 4 долоо хоногийн турш 12 удаа зүү эмчилгээ хийсэн. Эмчилгээний бүлэгт стандарт эмийн эмчилгээ хийхийн зэрэгцээ 12 удаагийн зүү эмчилгээ хийсэн бол хяналтын бүлэгт стандарт эмийн эмчилгээ хийсэн. Эмчилгээний үр дүнг АД-ын үед илрэх эмнэлзүйн шинжийн болон атопийн дерматитын хүндрэлийн үнэлгээ болох SCORAD үнэлгээний аргаар үнэлсэн. Амьдралын чанарыг арьсны эмгэгтэй хүмүүсийн амьдралын чанар үнэлэх (DLQI) асуумж судалгааны аргаар тооцсон. АД-ын үед хоёрдогчоор илрэх сэтгэл гутралын түвшинг (CES-D) асуумжийг ашиглан үнэлсэн. Зүү эмчилгээний бүлэгт хамрагдагсдын эмнэлзүйн шинж нь SCORAD үнэлгээгээр эмчилгээний өмнө 56.31±10.17 байсан бол эмчилгээний дараа 33.28±11.62 болж буурсан нь статистик ач холбогдол бүхий ялгаатай байна. Хяналтын бүлгийн SCORAD үнэлгээний дүн эмчилгээний эхэнд 53.39±6.35 байсан нь эмчилгээний дараа 42.82±5.95 болсон байна. Эмчилгээний бүлгийн хүмүүсийн тууралтын тархалт эмчилгээний өмнө 53.9%±21.13 байсан бол эмчилгээний дараа 27,01%±14.4 болж буурсан бөгөөд хяналтын бүлгийн тууралтын тархалт эмчилгээний эхэнд 52.21±12.67 байсан нь эмчилгээний дараа 39.71±10.66 болсон нь бүлгүүдийн хооронд 26.89 буюу статистик ач холбогдол бүхий ялгаатай байлаа. Эмчилгээний бүлгийн тууралтын эрчим 10.8± 2.1 байсан бол эмчилгээний төгсгөлд 6.3± 2.6 болж 4.5-аар буурсан хяналтын бүлгийн тууралтын эрчим эмчилгээний эхэнд 10.3±1.39 байсан нь эмчилгээний төгсгөлд 8.36±1.18 болсон бөгөөд зүү эмчилгээ нь тууралтын эрчимийг илүү бууруулж байна. Атопийн дерматитын шалтгаант сэтгэл гутралд зүү эмчилгээ нь статистик ач холбогдол бүхий ялгаатай үр нөлөөтэй. Эмчилгээний үр дүн сайн гарсан хамрагдагсдын амьдралын чанарт их болон дунд зэрэг сайжирсан харилцан хамаарал ажиглагдаж байна.

Үндэслэл

Атопийн дерматит нь элбэг тохиолдох олон дахилтат, хүчтэй загатнаа, арьсны харшлын тууралтаар илэрдэг арьсны өвчин юм. Хөгжингүй орнуудад сүүлийн 30 жилийн хугацаанд атопийн дерматитын тархалт 2-3 дахин ихэссэн бол Монгол улсын хувьд 2012 оноос хойш АД-ын тархалт тасралтгүй өсөх хандлага ажиглагдаж байна. АД-тай хүмүүсийн амьдралын чанарт хамгийн ихээр нөлөөлөх гол зовиур нь загатнаа юм. Мөн уурлах, ичих, сэтгэл санааны таагүй нөлөөгөөр загатнах, маажих хариу урвал илэрдэг байна. Атопийн дерматит нь олон дахилттай эмчилгээ олон жил үргэлжилж дааврын эм хэрэглэх шаардлагатай болдог тул эмийн бус эмчилгээний аргуудын үр дүнг үнэлсэн судалгааны ажлууд сүүлийн үед ихээхэн хийгдэх болсон. Тиймээс бусад улсуудад эмийн бус эмчилгээний нэг болох УАУ-ны зүү эмчилгээ судлаачдын сонирхолыг

татаж судалгаа шинжилгээ хийж байна. Манай оронд АД төдийгүй бусад төрлийн арьсны эмгэгүүдийн үед зүү эмчилгээг хийдэг боловч тус эмчилгээний үр дүнг тооцсон судалгааны ажил хийгдэж байгаагүй нь бидэнд энэхүү судалгааг хийх үндэслэл боллоо.

Зорилго, зорилт

Атопийн дерматитын үед илрэх эмнэлзүйн шинж тэмдгүүдэд зүү эмчилгээний үзүүлэх үр дүнг судлах

1. Атопийн дерматитын эмнэлзүйн шинжүүдэд зүү эмчилгээний үзүүлэх нөлөөг судлах
2. Атопийн дерматитын зүү эмчилгээний амьдралын чанарт үзүүлэх нөлөөг тодорхойлох
3. Атопийн дерматитын үед хоёрдогчоор илрэх сэтгэл гутралд зүү эмчилгээний үзүүлэх нөлөөг судлах

Арга аргачлал

Судалгааг санамсаргүй хяналтат эмнэлзүйн туршилт судалгааны загвараар нийт 60 хүнийг хамруулан компьютерийн программ ашиглан санамсаргүй түүвэрлэлтээр зүү эмчилгээний (n=30) болон хяналтын (n=30) бүлэгт хувааж 4 долоо хоногийн турш зүү эмчилгээ хийж үр дүнг тооцсон. Эмчилгээний бүлэгт стандарт эмийн эмчилгээ хийхийн зэрэгцээ 12 удаагийн зүү эмчилгээ хийсэн бол хяналтын бүлэгт стандарт эмийн эмчилгээ хийсэн. Бид судалгаандаа ерөнхий асуумж судалгаа, АД-ын хүндрэлийн зэрэг, амьдралын чанар, сэтгэл гутралын түвшин үнэлдэг асуумж судалгааг ашигласан. Ерөнхий асуумж судалгааны картаар судалгаанд хамрагдагсдын ерөнхий мэдээлэл, нас, хүйс, харшлын асуумж зэргийг үнэлж, АД-ын үед илрэх эмнэлзүйн шинжүүд болон хүндрэлийг SCORAD-(Consensus Report of the European Task Force on Atopic Dermatitis, 1993)-үнэлгээний аргаар, АД-ын үед хоёрдогчоор илрэх сэтгэл гутралын түвшинг АНУ-ын Тархвар зүйн судалгааны төвийн боловсруулсан сэтгэл гутралыг илрүүлэх (CES-D) асуумжийг ашиглан тогтоосон. Түүнээс гадна арьсны эмгэгийн үеийн амьдралын чанарын асуумжаар (DLQI) АД-тай хүмүүсийн амьдралын чанарт үнэлгээ хийсэн.

Үр дүн

Зүү эмчилгээнд хамрагдагсдын хувьд SCORAD үнэлгээгээр эмчилгээний өмнө 56.31±10.17 байсан нь эмчилгээний дараа 33.28±11.62 болж буурсан бөгөөд хяналтын бүлэгтэй харьцуулахад зүү эмчилгээ статистик ач холбогдол бүхий ялгаатай буюу зүү эмчилгээ үр дүнтэй байна. Хяналтын бүлгийн SCORAD үнэлгээний дүн эмчилгээний эхэнд 53.39±6.35 байсан нь эмчилгээний дараа 42.82±5.95 болсон байна. Тууралтын тархалтын хувь эмчилгээний өмнө 53.9%±21.13 байсан бол эмчилгээний дараа 27,01%±14.4 болж буурсан бөгөөд хяналтын бүлгийн тууралтын тархалт эмчилгээний эхэнд 52.21±12.67 байсан нь эмчилгээний дараа 39.71±10.66 болсон нь бүлгүүдийн хооронд 26.89 буюу статистик ач холбогдол бүхий ялгаатай байлаа. Тууралтын эрчим 10.8± 2.1 байсан бол эмчилгээний төгсгөлд 6.3±2.6 болж хяналтын бүлгийн тууралтын эрчим эмчилгээний эхэнд 10.3±1.39 байсан нь эмчилгээний төгсгөлд 8.36±1.18 болсон нь 4.5-аар буурсан буюу зүү эмчилгээ нь тууралтын эрчмийг бууруулж байна. VAS үнэлгээний дундаж нь эмчилгээний бүлэгт эмчилгээний өмнө 7,26±1.2 байсан нь эмчилгээний дараа 4,73±1.7 болж 2.53-аар буурсан, хяналтын бүлгийн VAS үнэлгээний дундаж нь эмчилгээний өмнө 6.93±1.31 байсан бол эмчилгээний дараа 5.63±1.42 болж буурсан байна. Судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн хувьд атопийн дерматитын шалтгаант сэтгэл гутралд зүү эмчилгээ нь статистик ач холбогдол бүхий ялгаатай үр нөлөөтэй. Харин амьдралын чанарт маш ихээр нөлөөлсөн үр дүн байгаагүй бол амьдралын чанарт ихээр болон дунд зэрэг нөлөөлсөн хүмүүст зүү эмчилгээ нь илүү үр дүнтэй байна.

Хүснэгт 1. Тууралтын идэвх тодорхойлсон байдал

Шинжүүд		Эмчилгээний бүлэг		Хяналтын бүлэг	
		Судалгааны эхэнд	Судалгааны төгсгөлд	Судалгааны эхэнд	Судалгааны төгсгөлд
		% (n)	% (n)	% (n)	% (n)
Улайлт**	байхгүй	0(0)	26.7(8)	0(0)	0(0)
	хөнгөн	10.0(3)	50.0(15)	13.3(4)	43.3(13)
	дунд	73.3(22)	23.3(7)	73.3(22)	56.7(17)
	хүнд	16.7(5)	0(0)	13.3(4)	0(0)
Хавдах**	байхгүй	13.3(4)	56.7(17)	10.0(3)	40.0(12)
	хөнгөн	40.0(12)	30.0(9)	56.7(17)	53.3(16)
	дунд	43.3(13)	13.3(4)	30.0(9)	6.7(2)
	хүнд	3.3(1)		3.3(1)	
Шүүдэс**	байхгүй	3.3(1)	60.0(18)	6.7(2)	30.0(9)
	хөнгөн	40.0(12)	40.0(12)	50.0(50)	46.7(14)
	дунд	56.7(17)	0(0)	36.7(11)	23.3(7)
	хүнд	0(0)	0(0)	6.7(2)	0(0)
Шалбархай**	байхгүй	3.3(1)	20.0(6)	3.3(1)	3.3(1)
	хөнгөн	36.7(11)	46.7(14)	23.3(7)	23.3(7)
	дунд	53.3(16)	30.0(9)	70.0(21)	70.0(21)
	хүнд	6.7(2)	3.3(1)	3.3(1)	3.3(1)
Ширшил**	байхгүй	3.3(1)	16.7(5)	0(0)	0(0)
	хөнгөн	30.0(9)	43.3(13)	46.7(14)	33.3(10)
	дунд	63.3(19)	40.0(12)	53.3(16)	66.7(20)
	хүнд	3.3(1)	0(0)	0(0)	0(0)
Арьсны хуурайшил	байхгүй	0(0)	3.3(1)	0(0)	0(0)
	хөнгөн	0(0)	16.7(5)	3.3(1)	23.3(7)
	дунд	53.3(16)	63.3(19)	63.3(19)	73.3(22)
	хүнд	46.7(14)	16.7(5)	33.3(10)	3.3(1)
Загатнаа VAS		7.26*	4.73*	6.93	5.63

**. Correlation is significant at the 0.01 level (2-tailed)

*. Correlation is significant at the 0.05 level (2-tailed)

Хүснэгт 2. Сэтгэл гутрал болон амьдралын чанарын байдал

Асуумж		Эмчилгээний бүлэг		Хяналтын бүлэг	
		Судалгааны эхэнд	Судалгааны төгсгөлд	Судалгааны эхэнд	Судалгааны төгсгөлд
		% (n)	% (n)	% (n)	% (n)
Сэтгэл гурталын түвшин	сэтгэл гутралгүй	30.0(9)	73.3(22)	20.0(6)	53.3(16)
	сэтгэл гутралтай	70.0(21)	26.7(8)	80.0(24)	46.7(14)
Амьдралын чанар	амьдралын чанарт нөлөөлөхгүй	0(0)	0(0)	0(0)	0(0)
	амьдралын чанарт бага зэрэг нөлөөлсөн	23.3(7)	16.7(5)	10.0(3)	3.3(1)
	амьдралын чанарт дунд зэрэг нөлөөлсөн**	0(0)	46.7(14)	6.7(2)	6.7(2)
	амьдралын чанарт их нөлөөлсөн**	76.7(23)	36.7(11)	83.3(25)	90.0(27)
	амьдралын чанарт маш ихээр нөлөөлсөн	0(0)	0(0)	0(0)	0(0)

Хэлцэмж

Атопийн дерматиттай өвчтнүүдэд зүү эмчилгээний үр нөлөөг судлах санамсаргүй хяналтат эмнэлзүйн туршилт судалгаа төдийлөн их хийгддэггүй бөгөөд өөрөөр хэлбэл энэ талаар хийгдсэн судалгаа хангалтгүй байдаг. Энэхүү судалгаагаар атопийн дерматитын эмнэлзүйн шинж тэмдэг, сэтгэл гутралын түвшин, амьдралын чанарт зүү эмчилгээ хэрхэн нөлөөлж байгааг хяналтын бүлэгтэй харьцуулан судаллаа. Юу Канг Ким нарын АД-ын загатнаанд зүү эмчилгээний үзүүлэх нөлөөг судалсан эмнэлзүйн туршилт судалгаанд нийт 30 хүнийг хамруулан гурван бүлэг болгон хувааж эмчилгээний үр дүнг тооцоход долоо хоногт 3 удаа нийт 4 долоо хоног зүү эмчилгээ хийсэн бүлгийн эмчилгээний үр дүн илүү байсан нь бидний судалгааны зүү эмчилгээний бүлгийн эмчилгээний хоногтой ижил хугацаа байгаа нь эмчилгээний үр дүнд 12 удаагийн зүү эмчилгээ нь илүү үр дүнтэй байж болох юм гэсэн дүгнэлтэнд хүрч байна. Мөн энэхүү судалгаанд дерматологийн амьдралын чанарыг үнэлсэн асуумж бидний судалгаандаа хэрэглсэн DLQI-ын асуумжтай ижил байгаа бөгөөд амьдралын чанарт их болон дунд зэрэг нөлөөлсөн бүлэгт зүү эмчилгээ нь илүү үр дүнтэй байлаа. Фироз нарын судалгаанд АД-тай хүмүүст загатнах зовиур 70%-д илэрдэг мөн арьсны хуурайшилт 40%-д нь хүнд хэлбэрээр явагдаж байна гэсэн дүгнэлт байгаа бөгөөд бидний судалгаанд хамрагдагсдын арьсны хуурайшил хөнгөн хэлбэрээр 1.7%, дунд зэргээр 58.3%, хүнд хэлбэрээр 40% илэрч байсан бол VAS үнэлгээний дундаж нь зүү эмчилгээний өмнө 7,26±1.2 байсан нь эмчилгээний дараа 4,73±1.7 болж 2.53-аар буурсан нь загатнах зовиурыг багасгаж байгаа нь АД-ын гол зовиурыг намдаах үр дүнтэй байлаа.

Дүгнэлт

Атопийн дерматитын зүү эмчилгээ нь тууралтын талбайг багасгаж, тууралтын эрчмийг бууруулж, загатналт болон загатналтын улмаас нойргүйдэх зовиурыг намдааж байна. Харин арьсны хуурайшилд эмчилгээний болон хяналтын бүлгийн хооронд ялгаа ажиглагдсангүй. Зүү эмчилгээ нь атопийн дерматитын үеийн амьдралын чанарыг сайжруулж байна. Зүү эмчилгээний дүнд сэтгэл гутралын түвшин буурч байна.

Талархал

Энэхүү судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд тусалж, зөвлөмж, зөвлөгөө өгсөн МАУОУС-ийн нийт эрдэмтэн багш нар, Эрдэм шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэх боломж, нөхцлөөр хангаж тусалж дэмжсэн МЯЭ-ийн МУАУУТөв, АӨСУТөвийн хамт олонд гүн талархал илэрхийлье.

Ном зүй

1. *Atopic dermatitis guidelines 2020. AAD (American Academy of Dermatology)*
2. *Textbook of Atopic dermatitis Sakari Reitamo, Thomas A.Luger, Martin Steinhoff*
3. *Acupuncture improves symptoms in patients with mild-to-moderate atopic dermatitis: A randomized, sham-controlled preliminary trial SeHyun Kang 1, Yu-Kang Kim 2, MijungYeom 3, Hyangsook Lee 4, Hyunchul Jang 5, Hi-Joon Park 6, Kyuseok Kim 7*
4. *The effectiveness and safety of acupuncture for patients with atopic eczema: a systematic review and meta-analysis Ruimin Jiao,1,2,* Zhongyang Yang,3,* Yang Wang,1 Jing Zhou,1,2 Yuxiao Zeng,1,2 and Zhishun Liu1,2*
5. *Epidermal barrier dysfunction in atopic dermatitis Michael J Cork, Simon Danby, YiannisVasilopoulos, ManarMoustafa, AlisMacGowan, Jibu Varghese, Gordon W Duff, RachidTazi-Ahinin and Simon J Ward*
6. *Quality of life in atopic dermatitis patients Matthias Augustin and Marc A Radtke*
7. *General management of patients with atopic dermatitis MarkBoguniewicz and Noreen Nicol*
8. *Mode of action of glucocorticoids Ekkehard May, Thomas Zollner, Heike Schacke, Stefanie Schoepe, HartmutRehwinkel, Wolfram Sterry and KhusruAsadullab*
9. *Clinical aspects of glucocorticoid treatment KristianThestrup-Pedersen*
10. *Phototherapy of atopic dermatitis Sonja A Grundmann and Stefan Beissert*

The effect of Acupuncture treatment for atopic dermatitis symptoms and impact on the quality of life

Lkhamjav.T[1], Khulan.B[1], Namgar.G[3], Enkhtur.Ya[2], Lagshmaa.B[1]
[1]International school of Mongolian Medicine, MNUMS
[2] Medical school, MNUMS
lkhamjav@mnums.edu.mn

ABSTRACT

Introduction: Atopic dermatitis (AD) is common, recurrent and pruritic disorder characterized by cutaneous allergic lesions. During the last 30 years the prevalence of atopic dermatitis in developed countries increased by 2-3 times. In Mongolia number of patients with AD tends to increase continuously since 2012. During recent years acupuncture has become a more popular treatment for AD, however in Mongolia there were conducted clinical studies assessing the effectiveness of this treatment. **Aim:** To evaluate the effectiveness of acupuncture for atopic dermatitis in terms of clinical symptoms and quality of life. **Material and method:** The randomized controlled trial with a parallel group design were conducted. Sixty participants were randomly divided to acupuncture (n=30) and control (n=30) groups. Furthermore, total of 12 acupuncture treatment sessions were done during 4 weeks. To evaluate outcomes of the treatment we used SCORAD, DLQI and CES-D questionnaires. Clinical symptoms and complications were evaluated by SCORAD (Consensus Report of the European Task Force on Atopic Dermatitis, 1993) level of depression due to AD was evaluated by Center for Epidemiological Studies Depression scale (CES-D). To evaluate the quality of life we used Dermatitis Life Quality Index (DLQI) questionnaire. **Results:** SCORAD test level at the baseline among patients was 56.31±10.17 and after treatment in acupuncture group the level was reduced to 33.28±11.62. Furthermore, the acupuncture therapy effectiveness was statistically significant in comparison with control group. Before acupuncture therapy, lesion distribution was 53.9%±21.13 and after therapy, lesion distribution was reduced to 27,01%±14.4. The difference was 26.89 which was statistically significant. Lesion severity was 10.8± 2.1 and at the end of therapy sessions, it reduced to 6.3± 2.6 by 4.5. This shows that acupuncture therapy effectively reduces lesion severity. The average VAS score was 7,26±1.2 before therapy and it reduced to 4,73±1.7 by 2.53 at the end of therapy sessions which shows that. Acupuncture therapy reduces itching. Moreover, acupuncture therapy is effective to reduce depression related to AD statistically significant. In contrary, the therapy did not effectively increase quality of life, but in individuals whose life quality increased, the acupuncture therapy was more effective. **Conclusion:** The acupuncture therapy for AD reduces the affected area, itching, severity and AD related insomnia. On the other hand, skin dryness was not effectively reduced in comparison between study group and control. Finally concluding, acupuncture therapy reduces depression